



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 11/13

Шивээговь сум

□ Сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, □
орон тоог батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, 67 дугаар зүйлийн 67.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.17, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12, Засгийн газрын 2009 онд батлагдсан “Сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоох тухай” 13 дугаар тогтоол, 2018 онд батлагдсан “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 267 дугаар тогтоол, 2024 оны “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 82 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”, аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн Б/03 дугаар захирамж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар “Сумын 2025 оны төсөв батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын орон тоог 24, үүнээс төрийн захиргааны, төрийн үйлчилгээний гүйцэтгэх үндсэн албан тушаалын орон тоог 18, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах төрийн үйлчилгээний туслах ажилтны бүтэц орон тоог 6 байхаар тогтоож нэгдүгээр хавсралтаар, төрийн үйлчилгээний анхан шатны нэгж багийн бүтэц орон тоог 2 байхаар тогтоож хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Сумын Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдлийг улсын төсвөөс 40 хувь, орон нутгийн төсвөөс 40 хувь, нийт 80 хувиар тооцон 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн бодож олгохыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал), Ахлах нягтлан бодогч (Л.Туяа) нарт зөвшөөрсүгэй.

421257038

3.Орон нутагт ажилласны нэмэгдэлд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн орон нутгийн төсөвт батлуулан ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын Санхүү албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Түвшинжаргал)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д тус тус үүрэг болгосугай.


4.Батлагдсан орон тоонд багтаан чиг үүргийн шинжилгээ хийж, давхардал, хийдэл үүсгэхгүйгээр оновчтой зохицуулалт хийж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА


Сумын Засаг даргын 2025 оны 04-р сарын 24-ны
өдрийн 13 дугаар захирамжийн 1-р хавсралт



СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ

Албан тушаалын нэр			
1. Удирдах бүрэлдэхүүн			
1	1.1.	Сумын засаг дарга	1
2	1.2.	Сумын засаг даргын орлогч	1
3	1.3.	Засаг даргын Тамгын газрын дарга	1
2. Санхүүгийн алба			
4	2.1.	Санхүү албаны дарга	1
5	2.2.	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	1
6	2.3.	ЗДТГ-ын Ахлах нягтлан бодогч	1
7	2.4.	ОНХС-н ХХСан хариуцсан ерөнхий нягтлан бодогч	1
8	2.5.	Нярав	1
3. Хөдөө аж ахуйн тасаг			
9	3.1.	Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн	1
10	3.2.	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1
11	3.3.	Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1
4. Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасаг			
12	4.1.	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод хяналт, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн	1
13	4.2.	Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	1
14	4.3.	Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн	1
15	4.4.	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	1
16	4.5.	Хууль эрх зүйн мэргэжилтэн	1
17	4.6.	Хэвлэл мэдээлэл харилцах ажилтан	1
18	4.7.	Архив, бичиг хэргийн эрхлэгч	1
Нийт			18
1. Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах үйлчилгээний туслах албан тушаалтан			
19	1.1.	Жолооч	1
20	1.2.	Үйлчлэгч -1	1
21	1.3.	Жижүүр - 3	3
22	1.4.	Сантехникийн слесарь	1
Нийт			6

Сумын Засаг даргын 2025 оны 01-р сарын 21-ны
өдрийн 113 дугаар захирамжийн 2-р хавсралт



БАГИЙН БҮТЭЦ ОРОН ТОО

Албан тушаалын нэр			Орон тоо
1. Удирдах бүрэлдэхүүн			
1	1.1.	1-р багийн Засаг дарга	1
2	1.2.	2-р багийн Засаг дарга	1
НИЙТ			2